
“ОЮУ ТОЛГОЙ” ХХК

БОЛОН

**“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ**

2022-2025 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

ХАМТЫН ГЭРЭЭ


Энэхүү 2022-2025 оны Хамтын гэрээ (цаашид “Хамтын гэрээ” гэх)-г 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр нэг талаас “Оюу Толгой” ХХК (цаашид “Ажил олгогч” гэх), нөгөө талаас “Оюу толгой” ХХК-ийн Уул уурхайн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороо (цаашид “ҮЭХ” гэх) Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

I БҮЛЭГ – ЕРӨНХИЙ ЗҮЙЛ БА НЭР ТОМЪЁО


- 1.1 Хамтын гэрээний заалтууд нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөлөөс дордоогүй байх бөгөөд хууль тогтоомжинд өөрчлөлт орж, энэхүү гэрээний заалтууд тухайн нөхцөлөөс дордсон бол тухай бүрд нийцүүлэх арга хэмжээг авна.
- 1.2 Энэхүү Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу зохих эрх бүхий байгууллагад бүртгүүлж, хүчин төгөлдөр болсноор хэрэгжиж эхлэх бөгөөд гурван (3) жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Энэ хугацаанд Талуудын нэмэлт, өөрчлөлт оруулах эрх хэвээр үлдэнэ.
- 1.3 Талууд Хамтын гэрээний 1.2 дах заалтад заасанчлан Хамтын гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн талуудын хооронд байгуулагдсан 2018-2023 оны Хамтын гэрээг дуусгавар болсонд тооцохоор харилцан тохиролцов.
- 1.4 Талууд арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй байдал, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг болон улс төрийн итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчинэ.
- 1.5 Энэхүү Хамтын гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - а. “Ажилтан” гэж “Оюу Толгой” ХХК-тай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэнийг;
 - б. “Бодлого” гэж Ажил олгогчоос баталж тухай бүрд гаргасан, компанийн бизнесийн санаа зорилгыг өргөн хүрээнд хамруулан тодорхойлсон баримт бичгийг;
 - в. “Оюу Толгой ХХК” гэж Ажил олгогчийг;
 - г. “Оюу толгой” гэж Оюу толгой төслийг;
 - д. “ҮЭХ” гэж “Оюу толгой” ХХК-ийн Уул уурхайн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороог;
 - е. “Уурхайн талбар” гэж Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших Оюу толгой төслийн үйл ажиллагаа явуулж буй талбарыг,
 - ё. “Уртын ээлжийн ажилтан” гэж хөдөлмөрийн гэрээний дагуу уурхайн талбарт байрлан, ажил үүргээ ажил, амралтын тэгш хуваариар гүйцэтгэдэг ажилтныг ойлгоно;
 - ж. “Тэтгэвэр/хуримтлалын сан” гэж ажилтан болон ажил олгогчоос сар бүр үндсэн цалингийн тодорхой хувиар оруулж буй хуримтлал.

II БҮЛЭГ – ЦАЛИН ХӨЛС

- 2.1 Ажилтан нь үндсэн цалингаас гадна холбогдох бодлого журмын дагуу олгох бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг авна.



- 2.2 Ажилтны цалин хөлсийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сард хоёр удаа олгоно.
- 2.3 Ажил олгогч нь зах зээлийн судалгааг жилд нэг удаа хийж, Монгол Улс дахь хэрэглээний үнийн индекс, инфляцийн түвшин, үндэсний хэмжээний цалингийн судалгаа болон бусад хүчин зүйлсэд аливаа өөрчлөлт орж буй эсэхийг хянан үзэж, дээрх судалгааны үр дүнг ҮЭХ-нд жил бүрийн 1-р улиралд багтаан танилцуулж байна. Хэрэв судалгааны үр дүнд илэрхий өөрчлөлт гарсан нь тогтоогдвол тухайн өөрчлөлтийн үндсэн цалинд нөлөөлөх байдлыг харгалзан үзэж цалинд өөрчлөлт оруулна.
- 2.4 Ажил олгогч нь нийт ажилтнуудын үндсэн цалинг 2022 онд 3 (гурав) хувь (үүнд 2022 оны 3 дугаар сард нэмсэн 1 хувийн үндсэн цалингийн нэмэгдэл багтсан)—иар 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс, 2023 онд 3 (гурав)-аас багагүй хувиар 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс болон 2024 онд 3 (гурав)-аас багагүй хувиар 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс тус тус нэмнэ. Энэхүү үндсэн цалингийн нэмэгдлээс гадна холбогдох бодлого, журмын шаардлагыг хангасан ажилтанд нэмэлтийг олгоно.
- 2.5 Ажил олгогч нь нийт ажилтнууд болон тэдний гэр бүл, үр хүүхдэд ирээдүйн санхүүгийн баталгаа бий болгох найдвартай ирээдүйг цогцлоох тэтгэврийн хуримтлалын сан (“Тэтгэвэр/хуримтлалтын сан”)-г үүсгэн, 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн ажилтнуудын үндсэн цалингийн 3 (гурав) хувьтай тэнцэх хэмжээний хуримтлалыг сар бүр Тэтгэвэр/хуримтлалын санд хуримтлуулна.
- 2.6 Ажилтнууд 2022 онд Тэтгэвэр/хуримтлалтын санд өөрийн зүгээс хуримтлал хийх шаардлагагүй бөгөөд энэ хугацаанд ажил олгогчийн зүгээс сар бүр Тэтгэврийн хуримтлалтын санд ажилтны үндсэн цалингийн 3 (гурав) хувьтай тэнцэх хэмжээний хуримтлалыг оруулна.
- 2.7 2023-2025 онд ажилтнууд Тэтгэвэр/хуримтлалын санд өөрсдийн зүгээс хуримтлалаа үе шаттайгаар оруулах ба энэ нь Ажил олгогчоос батлах холбогдох бодлого, журмаар нарийвчлан зохицуулагдана. Ажил олгогч холбогдох журам, бодлогыг батлахдаа ҮЭХ-ны саналыг харгалзан үзнэ.
- 2.8 Хамтын гэрээний 2.6, 2.7 дах заалтад зааснаас үл хамааран ажилтан өөрийн зүгээс үндсэн цалингийн 3 (гурав) хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хуримтлалыг Тэтгэврийн хуримтлалын санд оруулж болно.
- 2.9 Ажил олгогч нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээг жил бүрийн дөрөвдүгээр (4-р) улиралд хийж гүйцэтгэх бөгөөд уг үнэлгээгээр ажилтан, удирдах ажилтан хоёр харилцан санал бодлоо (санал, зөвлөгөө, шүүмжийг) солилцоно. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн нь Ажилтны жилийн урамшуулалтай холбогдоно.
- 2.10 Ажил олгогч нь бизнесийн (Оюу толгой ХХК үүнд Гүний уурхайн бүтээн байгуулалт хамаарна) гүйцэтгэлийн үр дүн болон бусад хүчин зүйлсийг харгалзан ажилтнуудад жилийн урамшуулал олгоно.
- 2.11 Ажил олгогч нь Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний сургалт, сурталчилгааг бүх шатны ажилтнуудад тодорхой, дэлгэрэнгүй хүргэх, үнэлгээний арга зүй, чанар, жигд хүртээмжид хяналт тавих, үнэлгээний аргачлал болон өөрчлөлтийн талаар ҮЭХ болон ажилтнуудад цаг тухайд нь мэдээлэл хүргэж байна.



- 2.12 Ажил олгогч нь шинэчилсэн найруулсан Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд дунджаар 25 (хорин тав) болон түүнээс дээш хувиар цалин хөлс нь буурсан ажилтнуудын нөлөөллийг нягтлан үзэж, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.
- 2.13 Уртын ээлжийн ажилтны ажил үүрэг гүйцэтгэх 14 хоногт өдөрт 8 цагаас илүү ажилласан илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгох эсэх тухай асуудлыг Монгол Улсын Дээд шүүх энэхүү асуудлаар албан ёсны тайлбар гаргах хүртэлх хугацаанд Талууд хэлэлцэхгүй ба уг асуудлаар ҮЭХ-ны зүгээс аливаа хамтын болон иргэний маргаан үүсгэхгүй, шүүхэд нэхэмжлэл гаргахгүй байхаар Талууд харилцан тохиролцов. Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар гаргуулахаар Талууд өөрсдийн төлөөллийн байгууллагуудаар дамжуулан эсхүл хамтран хичээл зүтгэл гарган ажиллана. Ажилтан энэ асуудлаар маргаан үүсгэх тохиолдолд Талуудын тохиролцсон нөхцөлийг тухайн ажилтанд тайлбарлах, Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар гарах хүртэл маргаан үүсгэхээ түдгэлзэхийг зөвлөх тал дээр Талууд хамтран ажиллана. Мөн ҮЭХ энэхүү нөхцөлийн талаар ажилтнуудад мэдээлж, тайлбар өгөх үүргийг хүлээнэ.

Нэмэгдэл, нэмэгдэл хөлс

- 2.14 Шөнийн ээлжийн нэмэгдэл хөлс - Хуваарьт ээлжээр оройн 10:00 (22:00) цагаас өглөөний 6:00 (06:00) цагийн хооронд ажилладаг ажилтанд энэ хугацааны ажилласан цагт нь дундаж цалин хөлсийг 1.2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно.
- 2.15 Уртын ээлжийн ажилтан нийтээр амрах баярын өдөр ажилласан тохиолдолд үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгоно. Энэ нь 2.13 дах заалтад заасан илүү цагийн нэмэгдэл хөлсийн талаар тайлбар гарах хүртэлх хугацаанд үйлчилнэ.
- 2.16 Байршлаас хамаарах нэмэгдлүүд:
- Уртын ээлжийн нэмэгдэл: Уртын ээлжийн нэмэгдэл нь сарын үндсэн цалингийн 13% (арван гурав)-тай тэнцэх бөгөөд уг нэмэгдлийг уртын ээлжийн ажилтанд олгоно.
 - Хоол, унааны нэмэгдэл: 500,000 (таван зуун мянга) төгрөгийн хоол унааны нэмэгдлийг байнга ажилладаг газар болон гэрийнхээ хооронд өдөр тутам ирж буцах боломжтой ажил амралтын хуваарьтай Ажилтны хоол унааны зардалд нэмэр болох зорилгоор олгоно.
 - Хэрэв Ажилтан уурхайн талбар болон оффист ээлжлэн ажиллах батлагдсан хуваарьтай бол дээр дурдсан хоёр нэмэгдлийг авч болох ба эдгээр нэмэгдлүүдийг тус бүрд ажилласан хугацаанд нь тооцон олгоно. Ажилтанд 2.16 (а), (б)-д заасан нэмэгдлүүдийг давхардуулан олгохгүй.
- 2.17 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн үнэлгээгээр тогтоогдсон нөхцөлд ажиллаж буй Ажилтанд Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай бодлогын дагуу хөнгөлөлт, нэмэгдлийг олгоно.
- 2.18 Ажилтан нь удирдлагын шийдвэрийн дагуу өөр ажилтны ажил үүргийг хавсран буюу хослон ажилласан бол үндсэн цалингийн 15% (арван тав)-тай тэнцэх хэмжээний Ажил үүргийг хавсран болон хослон гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг тухайн хугацаанд нь тооцон олгоно.
- 2.19 Ажилтан нь удирдлагын шийдвэрийн дагуу удирдах ажилтны ажил үүргийг орлон гүйцэтгэх шаардлагатай болсон бол үндсэн цалингийн 20% (хорь)-тай тэнцэх хэмжээний Өндөр хариуцлага бүхий ажил үүргийг орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг тухайн хугацаанд нь тооцон олгоно.

- 2.20 Ажилтан нь удирдлагатайгаа харилцан зөвшилцсөн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгэсэн ба тусгай төсөл, сургалтын үйл ажиллагааны хүрээнд ажлын байрны тодорхойлолтод зааснаас өөр ажил үүрэг гүйцэтгэх тохиолдолд хавсран болон хослон эсвэл орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгогдохгүй.
- 2.21 Ажилтанд эрдмийн зэрэг, цолны болон мэргэшлийн цол зэргийн нэмэгдлийг ажлын үр дүнтэй уялдуулан дараах байдлаар зохицуулан олгоно.
- Ажил олгогч нь иргэнийг ажилд авахдаа тухайн ажлын байранд зайлшгүй шаардлагатай ур чадвар, мэргэшлийн зэрэг дэв, эрдмийн цолыг ажлын байрны тодорхойлолтонд тусгана.
 - Тухайн ажилтны цалин ба албан тушаалын зэрэглэлийг тогтоохдоо 2.21.(а) заалт болон бусад зайлшгүй шаардлагатай хүчин зүйлсийг харгалзана.
 - Ажил олгогч нь ажилтанд тухайн ажил үүрэгтэй нь холбоотой мэргэшлийн зэрэг дэв, эрдмийн цолны нэмэгдлийг холбогдох төрийн байгууллагын журамд заасны дагуу үндсэн цалингийн зохих хувиар олгоно.
 - Ажлын шаардлагаар зэрэг дэв авах, дээшлүүлэх, мэргэшлийн зэргийн үнэмлэхний хугацааг сунгахтай холбоотой зардлыг Ажил олгогч хариуцна.

Уг нэмэгдлийг олгохдоо нотлох бичиг баримт, үнэмлэх зэргийг үндэслэнэ.

- 2.22 Энэхүү Хамтын гэрээний хэрэгжилтийн хугацаанд Ажил олгогч нь цалин бодолтыг хялбарчлах, цалин бодох аргачлалын талаар ажилтнуудын ойлголтыг сайжруулах зорилгоор тодорхой арга хэмжээ авна.
- 2.23 Аюулгүй ажиллагааг бүрэн хангах зорилгоор ажил хүлээлцэх хугацааны зохих олговрыг үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах бизнесийн шаардлагын дагуу тодорхойлж олгоно.

Орон тоо цомхотгох ба өөр ажилд шилжүүлэх

- 2.24 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол ажилтны үндсэн цалингийн 70% (дал)-тай тэнцэх хэмжээний олговрыг сул зогсолтын хугацаанд олгоно.
- 2.25 Доор дурдсан үндэслэлүүдээр тухайн ажлын байранд хамаарах хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болох ажилтныг компанийн өөр газар, хэлтэс, хэсэг рүү урьд нь авч байсан цалин хөлсийг аль болох бууруулахгүйгээр тохирох ажлын байранд шилжүүлэх арга хэмжээ авна. Үүнд:
- Аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан;
 - Орон тоо хасагдсан;
 - Ажилтны тоог цөөрүүлсэн;
 - Эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон.
- 2.26 Энэхүү Хамтын гэрээний 2.25 дугаар зүйлийн а, б, болон в дэх заалтуудад заасан үндэслэлүүдээр тухайн ажлын байранд хамаарах хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдах ажилтныг компанийн өөр газар, хэлтэс, хэсэгт шилжүүлэх боломжгүй үед Оюу Толгой ХХК-д ажилласан хугацаанаас хамаарч дараах хэмжээний тэтгэмжийг 1 (нэг) удаа олгоно:
- 0-4 жил ажилласан бол 3 сарын үндсэн цалин;
 - 4-5 жил ажилласан бол 3.5 сарын үндсэн цалин;
 - 5-6 жил ажилласан бол 4 сарын үндсэн цалин;
 - 6-7 жил ажилласан бол 4.5 сарын үндсэн цалин;
 - 7-8 жил ажилласан бол 5 сарын үндсэн цалин;

- е. 8-9 жил ажилласан бол 5.5 сарын үндсэн цалин;
 - ё. 9 жилээс дээш ажилласан бол 6 сарын үндсэн цалин.
- 2.27 Ажилтан ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдаж, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдож хөдөлмөрийн гэрээ цуцлах тохиолдолд ажилтанд 12 (арван хоёр) сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 1 (нэг) удаа олгоно.
- 2.28 Ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болох нь тогтоогдож хөдөлмөрийн гэрээ цуцлах тохиолдолд Хамтын гэрээний 2.26 дах заалтад заасны дагуу ажилласан жилээс хамааран нэг удаагийн тэтгэмжийг Ажилтанд олгоно.
- 2.29 Ажил олгогч нь нийт ажилтны цалин хөлс, олговор, нэмэгдлийг бууруулах, өөрчлөлт оруулах тохиолдол бүрт шийдвэр гарахаас ажлын 10 (арав) хоногийн өмнө ҮЭХ-нд мэдэгдэж саналыг авч, өөрчлөлт оруулна.

III БҮЛЭГ – АЖИЛТНЫ СУРГАЛТ, МЭРГЭЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- 3.1 Ажил олгогч нь Ажилтныг компанийн хэрэгцээ шаардлага болон тухайн ажилтны өөрийн чадвар, хүсэл сонирхолд нийцсэн сургалтанд хамруулж мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх боломжоор хангана. Компанийн болон хувь хүний мэргэжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ажилтан суралцах, өөрийгөө хөгжүүлэх бололцоог бүрдүүлсэн Хувийн хөгжлийн төлөвлөгөөг ажилтнуудад танилцуулна.
- 3.2 Ажил олгогч нь ажилтнуудыг аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчны шаардлагуудыг ханган, хариуцлагатайгаар ажил үүргээ хийж гүйцэтгэхэд зориулан сургалтанд хамруулна. Ажилтан бүр компанийн шаардлагаар Ажил олгогчоос зохион байгуулж буй аюулгүй ажиллагааны болон ажил үүрэгтэй нь холбоотой сургалтанд оролцох боломжтой. Компанийн хэмжээнд явуулах сургалтын хөтөлбөрүүд нь ажлын байрны/ажил дээрх сургалтууд болон компаниас гадуур явуулах ажил үүргийн холбоотой урт болон богино хугацааны сургалтыг хамарна.
- 3.3 Ажил олгогчоос зохион байгуулж буй сургалтанд хамрагдсан Ажилтанд сургалтын хугацааны ажлын хөлсийг цалин бодох тогтсон аргачлалын дагуу бодож олгоно.
- 3.4 Ажилтан өөрийн мэдлэг боловсрол, ур чадвараа хөгжүүлэхэд эзэн нь байж ажлын байран дээрээ тасралтгүй суралцахыг эрмэлзэн ажиллана. Өөрийгөө хөгжүүлэх санаачлага гаргасан ажилтанд компанийн Авъяас, ур чадварыг хөгжүүлэх стратегийн хүрээнд бизнесийн хэрэгцээ шаардлагыг харгалзан, ажилтны ажил үүрэг, хувийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн дэмжлэг үзүүлнэ.
- 3.5 Ажил олгогч нь монгол ажилтнуудыг сургаж хөгжүүлэх манлайллын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Эдгээр хөтөлбөрүүд нь монгол ажилтнуудын манлайлах, удирдах ур чадварыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.6 Ажил олгогч нь Оюу Толгой ХХК-д залгамж халаа бэлдэх төлөвлөгөөг боловсруулна. Тус төлөвлөгөө нь байгууллагын бүх түвшинд монгол ажилтнуудыг сургаж хөгжүүлэх, албан тушаал ахиулах боломжийг олгоно. Ажил олгогчоос ажлын байр тус бүр дээр шаардагдах мэргэжлийн ур чадвар, туршлагатай, тохирох шилдэг нэр дэвшигчийг шалгаруулж тодорхойлно.

IV БҮЛЭГ – АЖИЛ АМРАЛТЫН ХУВААРИЙН ТАЛААР

... сарын ... ны өдөр

- 4.1 Уртын ээлжийн ажилтнуудад ажил үүрэг гүйцэтгэх 14 хоног, амрах 14 хоног байх уртын ээлжийн хуваарийг ажил олгогч хэрэгжүүлнэ.
- 4.2 Хамтын гэрээний 4.1 дэх заалтад заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байх ажил амралтын хуваарийг ажилтантай тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлж болно.
- 4.3 Ажил олгогч нь Ажилтны ажил, амралтын хуваарь болон ээлжийг өөрчилж болно. Энэ тохиолдолд 7 хоногийн өмнө мэдэгдэх ба ажилтны ар гэр, эрүүл мэнд болон бусад онцгой нөхцөлийг харгалзан үзнэ.
- 4.4 Ажилтан нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон компанийн бодлого журмын дагуу ээлжийн амралт эдлэх, нөхөн эдлэх, ээлжийн амралтын цалин авах эрхтэй.
- 4.5 Хэрэв Ажил олгогчийн хүсэлтээр ажилд дуудагдсаны улмаас тухайн жилдээ амралтаа биеэр гүйцэд эдлээгүй бол хэлтсийн менежерийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр тухайн ажилтан эдлээгүй амралтын хоногоо нөхөн амарна.
- 4.6 Ажилтанд өвчний чөлөө, гэрлэлтийн чөлөө, гашуудлын болон гэр бүлийн шалтгаанаар авах чөлөөг холбогдох олговрын хамт Чөлөө олгох тухай бодлогын дагуу тооцон олгоно.
- 4.7 Байгалийн гэнэтийн хүчин зүйлсийн улмаас үүссэн ажилтны хувийн нөхцөл байдлыг харгалзан гурав (3) хүртэлх хоногийн цалинтай Онцгой шалтгааны хувийн чөлөөг Чөлөө олгох бодлого, журамд тодорхойлсны дагуу олгоно.
- 4.8 Монгол улсыг төлөөлөн олон улсын арга хэмжээнд оролцож буй Ажилтанд жилд тав (5) хүртэлх хоногийн урлаг, спортын арга хэмжээний чөлөөг Чөлөө олгох бодлого, журамд тодорхойлсны дагуу олгоно.
- 4.9 Үндэсний хэмжээний спортын тэмцээнд оролцож буй ажилтанд 5 хүртэлх өдрийн олговортой чөлөө, салбарын тэмцээнд оролцож буй ажилтанд 3 хүртэлх өдрийн олговортой чөлөө олгоно.

V БҮЛЭГ – ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

- 5.1 Ажил олгогч болон Ажилтан нь ажил үүргээ аюулгүй хийж гүйцэтгэхийн төлөө хамтран хичээж ажиллана. Ажил олгогч нь Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, стандартын дагуу аюулгүй ажлын байраар хангана. Ажил олгогч нь Оюу толгойн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд (ЭМАА) дэлхийн шилдэг тэргүүний практик туршлагыг нэвтрүүлэх мөн ЭМАА-г бүх талаар тогтмол шинэчлэн сайжруулах зарчмыг баримтлан ажиллана.
- 5.2 Ажил олгогч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - а. Оюу Толгой ХХК-ийн ажлын байранд шалгарсан нэр дэвшигчийг ажил эхлэхээс өмнөх эмнэлгийн үзлэгт хамруулна;
 - б. Ажилтныг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 (нэг) удаа ажил олгогчийн зардлаар хамруулах ба Засгийн газрын тогтоол журамд заасны дагуу нэмэлт үзлэгт оруулж болно;
 - в. Ажилтанд ажлын шаардлагынх нь дагуу өндөр чанартай Хувийн хамгаалалтын хувцас хэрэгслээр (ХХХХ) цаг хугацаанд нь үнэ төлбөргүй хангана.
 - г. ЭМАА-ны ерөнхий болон ажлын байрны тусгай зориулалтын сургалтыг зохион явуулна;

- д. ЭМАА-ны хороог нийт ажилтнуудаас сонгогдсон төлөөлөгч, компанийн удирдлагын болон ЭМАА-ны хэлтэс мөн ҮЭХ-ны гишүүнийг оролцуулан уурхайн талбарт байгуулна. Тус хороо нь тогтмол хуралдаж өдөр тутмын үйл ажиллагаанд гарсан эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулж, төслийн хэмжээнд хөдөлмөрийн орчинг сайжруулах чиглэлээр ажиллана;
- е. Аюулгүй ажиллагаатай холбоотой Ажилтан эсвэл Гэрээт компанийн ажилтнаас гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэнэ.

5.3 Ажилтан дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- а. Тухайн ажлын арга барил эсвэл нөхцөл байдал нь аюултай гэж үзвэл ажлаа даруй зогсооно.
- б. Аливаа аюул осолтой ажлын арга барил, нөхцөл байдлын талаар албан ёсоор удирдах ажилтандаа цаг алдалгүй мэдэгдэнэ.
- в. ХХХХ-ээ байнга арчилж, зориулалтын дагуу өмсөж хэрэглэнэ.
- г. Аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг шууд удирдлагадаа мэдэгдэнэ.
- д. Удирдлагын заавар болон ЭМАА-ны дүрэм журмыг мөрдөнө.

5.4 ҮЭХ нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- а. ЭМААБО-ны хорооны гишүүний хувиар үйл ажиллагаанд нь хариуцлагатай оролцоно.
- б. ХХХХ-ийн хорооны гишүүний хувиар үйл ажиллагаанд нь хариуцлагатай оролцоно.
- в. Хоолны хорооны гишүүний хувиар үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- г. Үйлдвэрлэлийн осол судлан бүртгэх комиссын гишүүний хувиар үйл ажиллагаанд нь хариуцлагатай оролцоно.
- д. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын үйл ажиллагаанд тогтмол, хариуцлагатай оролцоно.

5.5 Ажил олгогч нь албан ёсоор тодорхойлогдсон хэвийн бус нөхцөлийг хүлээн зөвшөөрч Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай бодлогын дагуу холбогдох нэмэгдэл хөлс, хөнгөлөлтийг олгоно.

5.6 Ажил олгогч нь ажлын байруудад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллагаар хуулийн дагуу хийлгэнэ. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх бэлтгэл ажлын хэсэгт ҮЭХ-ны төлөөллийг оролцуулж, тайлан мэдээллийг тогтмол өгч байх үүргийг хүлээнэ.

5.7 Ажилтанд олгох ХХХХ-нь түүний ажлын шаардлагад нийцсэн байна. ХХХХ-ийн хангалт, чанартай холбоотой аливаа санал хүсэлтийг ажилтан эхний удаад удирдах ажилтандаа хандан гаргана. Хэрэв асуудал эс шийдэгдсэн тохиолдолд уг асуудлыг Оюу толгой дахь ХХХХ-ийн хороонд мэдэгдэнэ. ХХХХ-ийн зөвлөлдөх хорооны бүрэлдэхүүнд ҮЭХ-ноос нэгээс доошгүй төлөөлөгч оролцоно.

5.8 ЭМАА-ны хороон дахь ҮЭХ-ийн төлөөлөгч нь энэхүү гэрээний хамрах хүрээнд багтсан Ажилтны осолд өртсөн шалтгааныг судлан тогтоох ажилд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу оролцож болно.

5.9 Ажил үүрэгтэй холбоотой аливаа осол, гэмтэл эсвэл өвчлөлийг холбогдох бодлого журмууд болон тэдгээрт оруулсан өөрчлөлтийн дагуу шийдвэрлэнэ. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн холбоотой ЭМАА-ны бодлого журмуудыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудад нийцүүлнэ.

- 5.10 Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан Ажилтныг Эмнэлэг Хөдөлмөрийн Магадлах Комисс (ЭХМК)-ын албан ёсны дүгнэлтийг харгалзан, түүнд тохирох өөр ажилд шилжүүлж болно.
- 5.11 Ажил олгогч нь ажлын байран дахь ажилтны эрүүл энх байдлыг чухалчлан ажлын байр болон ажлаас гадуур өдөр тутмын үйл ажиллагаандаа эрүүл, энх байдлын зарчмыг сахин мөрдөхийг дэмжинэ.
- 5.12 Ажил олгогч нь эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудыг ХАБЭА-ын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу амь нас, эрүүл мэндийн даатгалд даатгуулна.
- 5.13 Ажил олгогч нь нийт ажилтнуудыг гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд даатгуулна.
- 5.14 Аливаа төлөвлөөгүй, гэнэтийн зогсолт хийх нь уурхайн тасралтгүй үйл ажиллагаанд нөлөөлөх тул талууд компаниас аливаа удирдамж заавар өгөх эсвэл аюулгүй ажиллагааны ноцтой шалтгааны улмаас үйлвэрлэлийг зогсоохоос бусад тохиолдолд, гүний уурхайн тасралтгүй үйл ажиллагаанд нөлөөлж зогсоохгүйгээр тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллахаар тохиролцов. Ажил олгогч үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах шаардлагатай ажлын байрны жагсаалтыг гаргана.

VI БҮЛЭГ – АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, АЖЛЫН БАЙРНЫ БАТАЛГААНЫ ТАЛААР

- 6.1 Ажил олгогч нь ялгаварлан гадуурхлаас ангид ажлын байраар хангана. Ажил олгогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тус Компанид ажилд орох болон ажиллахад нь дэмжлэг болох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.2 Энэхүү Хамтын гэрээний хүчин төгөлдөр хугацаанд Ажилтан хуулийн дагуу тэтгэвэрт гарах болсон тохиолдолд түүнд 9 (есөн) сарын үндсэн цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно. Энэхүү тэтгэмжийг Ажилтны тэтгэвэрт гарахдаа авч буй сүүлийн цалинтай хамт олгоно.
- 6.3 Удаан хугацаанд ажилласан Ажилтны хувь нэмрийг үнэлэх үүднээс Ажил олгогч нь ажилтны Оюу Толгой ХХК-д тасралтгүй ажилласан 5 жилээс эхлэн үнэлж урамшуулах ба ажилласан жилээс хамааран дараах байдлаар үнэлж урамшуулна:
- 5 жилийн ойгоор 550,000 (таван зуун тавин мянга) төгрөг;
 - 10 жилийн ойгоор 1,000,000 (нэг сая) төгрөг;
 - 15 жилийн ойгоор 3,000,000 (гурван сая) төгрөг;
 - 20 жилийн ойгоор 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөг;
 - 25 жилийн ойгоор 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөг;
 - 30 жилийн ойгоор 6,500,000 (зургаан сая таван зуун мянга) төгрөг.
- 6.4 "Монгол Улсын төр, засгийн газрын шагналд нэр дэвшүүлэх" журмын дагуу Ажилтныг төрийн болон салбарын шагналд тодорхойлно. Байгууллагын зүгээс нэр дэвшүүлж, Ажилтан төрийн болон салбарын шагналаар шагнагдсан тохиолдолд дор дурьдсан хэмжээгээр мөнгөн шагнал олгоно. Үүнд:
- Салбарын жуух бичгээр шагнагдсан ажилтанд 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг;

- б. Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан ажилтанд 800,000 (найман зуун мянга)төгрөг;
 - в. Төрийн шагналаар шагнагдсан ажилтанд 2,000,000 (хоёр сая) төгрөг.
- 6.5 Ажил олгогч нь жил бүр гарамгай амжилт гаргасан 5-аас доошгүй ажилтныг үнэлж, урамшуулах зорилгоор туршлага судлах танилцах олон улсын бизнес аялалд хамруулна.
- 6.6 Ажил олгогч болон ҮЭХ нь Оюу толгой төслийн арилжааны түншүүд болон үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагатай хамтран Ажилтанд зориулсан Хөнгөлөлт үзүүлэх хөтөлбөр боловсруулах боломжийг судална.
- а. Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийг дэмжих зорилгоор магадлан итгэмжлэгдсэн сувиллын байгууллагад хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэхэд ҮЭХ-той бүх талаар хамтарч, дэмжин ажиллана.
- 6.7 Ажил олгогч өөрийн зардлаар нийт ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна. Даатгалын тохиолдол үүссэн бол ажил олгогч гэр бүлд нь тухайн ажилтны 12 (арван хоёр) сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.
- 6.8 Ажил олгогч ажилтны гэр бүлийн гишүүн нас барах тохиолдолд буяны ажилд зориулан 5 (тав) сая төгрөг, ажилтан нас барах тохиолдолд Хамтын гэрээний 6.7 дах заалтад заасан тэтгэмжээс гадна буяны ажилд зориулан 10 (арав) сая төгрөг болон 3 (гурав) сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламжийг олгоно.
- 6.9 Шинээр хүүхэдтэй болсон эцэгт 18 (арван найм) долоо хоногийн цалинтай чөлөө олгоно.
- 6.10 Ажил олгогч нь эх үрсийн баярыг тохиолдуулан ажилтнуудынхаа хүүхэд бүрт (16 хүртэлх насны) бэлэг өгнө.

VII БҮЛЭГ – ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


- 7.1 Ажил олгогч нь ҮЭХ-ны хэрэгцээнд зориулан боломжтой үед Оюу толгой уурхайн талбарт ажлын өрөөгөөр хангана.
- 7.2 Ажил олгогч нь ҮЭХ-г ажлын байрны тохиромжтой газруудад мэдээллийн самбар байрлуулах боломжоор хангана.
- 7.3 Ажил олгогч нь ҮЭХ-ноос зохих хугацааны өмнө урьдчилан ирүүлсэн мэдэгдэл дээр үндэслэн ҮЭХ-ны даргыг сард нэг (1) удаа, хоёр (2) хоногийн хугацаагаар Оюу толгой уурхайн талбарт ажиллах үед байр болон хоолоор хангана.
- 7.4 Хүсэлтийн дагуу болон харилцан тохиролцсоныг үндэслэн, Ажил олгогч нь улиралд 1 удаа ҮЭХ-ны даргыг Оюу толгойн уурхайн талбар руу ирэх, очих нислэгийн зардлыг хариуцна. Ажил олгогчийн зүгээс ҮЭХ-ны даргыг Оюу толгойн уурхайн талбарт урьсан тохиолдолд нислэгийн зардлыг Ажил олгогч хариуцна.
- 7.5 Энэхүү гэрээний хэрэгжилтийн хугацаанд, Ажил олгогч нь ҮЭХ-ны гишүүнчлэлийн татварыг Ажилтны цалингаас нь суутгана. Тус суутгалыг Ажилтны бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хийх болно. Ажилтан бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд гишүүний татвар хураах ажлыг ҮЭХ өөрөө хариуцна.

- 7.6 Гэрээний хэрэгжилтийн хугацаанд, Ажил олгогч нь гишүүдийн цугласан татварыг цалин тавьж олгосноос хойш ажлын 5 (тав) өдөрт багтаан ҮЭХ-ны дансанд нэг удаагийн төлбөрөөр шилжүүлнэ.
- 7.7 Ажил олгогч нь шаардлагатай үед ҮЭХ-той уулзалт, хурал зохион байгуулахдаа Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон хамтын ажиллагааны зарчмыг баримтална.
- 7.8 Хуулийн дагуу, ҮЭХ-ны гишүүнийг ҮЭХ-ны үйл ажиллагаанд оролцсоных нь төлөө ажлаас халах эсвэл албан тушаал бууруулж үл болно. Албан тушаал эсвэл үүрэг хариуцлагаас нь үл хамааран Ажил олгогч нь байгууллагын бодлого журам, зохицуулалтын дагуу ажилтнуудаа удирдан зохион байгуулах эрхээ хадгална.
- 7.9 ҮЭХ эсвэл Ажил олгогчийн хүсэлтээр, талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх, хяналт тавихад холбогдолтой гэж үзсэн мэдээллийг харилцан солилцоно.
- 7.10 ҮЭХ нь энэхүү гэрээний нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх явцад эсвэл ээлжит хурал уулзалтын үеэр удирдлагын төлөөлөгчдөөс амаар эсвэл бичгээр авсан компанитай холбоотой аливаа нууц мэдээллийг ажилтнууд болон гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 7.11 Компанийн захиргаа болон ҮЭХ-ны дарга (түүний төлөөлөл) долоо хоног бүр уулзаж ажилчдын санал хүсэлтийг хэлэлцэнэ.
- 7.12 ҮЭХ-ны тэргүүлэгч гишүүдийн нэгдсэн хурлыг жилд 2 (хоёр) удаа хийхэд тэргүүлэгч нарт цалинтай чөлөө олгоно.

VIII БҮЛЭГ – ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР

- 8.1 Энэхүү Хамтын гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу зохих төрийн байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд ийнхүү хүчин төгөлдөр болсны дараа ажилтнуудын хүртээл болгоно.
- а. Хамтын гэрээний хэрэгжилтийн явцыг хянах процессийг талууд харилцан ойлголцлын санамж бичгээр тохирно.
- б. Харилцан ойлголцлын санамж бичгээр тохирсны дагуу, 12 (арван хоёр) сар тутамд хэрэгжилтийг хянах үед аль нэг тал нь нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, хэлэлцээг Хөдөлмөрийн хуульд заасны дагуу эхлүүлнэ.
- 8.2 Энэхүү Хамтын гэрээний хугацаа дуусах үед талуудын аль нэг нь цуцлах эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах талаар бичгээр мэдэгдээгүй тохиолдолд Гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцно.
- 8.3 Хамтын гэрээний хэрэгжилтийн эхний 6 (зургаа) сард ямар нэгэн өөрчлөлт үл хийгдэнэ.
- 8.4 Талууд Хамтын гэрээг боловсруулах, хянах, хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажлын цагаар хийх ба үүнд оролцсон Ажилтнуудын цалин хөлсийг ажилласнаар тооцон олгоно. Хамтын гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх зорилгоор жил бүрийн эхний улиралд гэрээний хэрэгжилтийн нэгдсэн хурлыг хийнэ.

- 8.5 Хамтын гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд ийнхүү хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд уг маргааныг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 8.6 Ажилтан болон Ажил олгогчийн хооронд үүссэн аливаа маргааныг Ажилтны Санал гомдлыг барагдуулах тухай бодлогын дагуу талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 8.7 Энэхүү Хамтын гэрээг Англи, Монгол хэл дээр үйлдэх бөгөөд Хамтын гэрээний агуулга, утга буюу тайлбартай холбоотой зөрүү гарсан тохиолдолд Монгол эхийг баримтална.





“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Э. Анхбаяр
Гүний уурхайн суурин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний менежер

Ж. Эрдэнэбилэг
Хөдөлмөрийн харилцаа хариуцсан менежер

М. Ганболд
Баяжуулалтын техникийн үйл ажиллагаа хариуцсан менежер

А. Алтаншагай
Баяжуулалтын засвар үйлчилгээний менежер

Х. Бат-Ундрах
Цалин урамшууллын мэргэжилтэн

Б. Энхмаа
Хуульч

Б. Төгсболд
Бизнесийн шинжээчийн ахлах зөвлөх

Т. Одгэрэл
Хүний нөөцийн төслийн мэргэжилтэн

Б. Цогтсайхан
Санхүүгийн бизнес түншлэлийн менежер



“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:

Г. Баярмаа
ҮЭХ-ны дарга

П. Өнөболд
Геотехникийн ахлах инженер

Д. Золжаргал
Гүний уурхайн босоо амны үйл ажиллагааны сургагч

Э. Хатанбаатар
Баяжуулахын оператор

Т. Оюун-Эрдэнэ
Аюулгүй ажиллагааны зөвлөх

Т. Тэнгэс
Механикийн ахлах инженер

Н. Эрдэнэбаяр
Сэлбэг хэрэгслийн зохицуулагч

А. Үнэнбат
Босоо амны оператор

Г. Билгүүдэй
Өргүүрийн ахлах инженер

БҮРТГЭВ № 18

2022 оны 04-р сарын 22-ны өдөр